

Дэлгэрэнгүй



ДУНДГОВЬ АЙМАГ

**СУМЫН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

МАНДАЛГОВЬ

АГУУЛГА

НЭГ.ЗОРИЛГО

ХОЁР.ҮНДЭСЛЭЛ АРГА ЗҮЙ

ГУРАВ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1 Сумын Засаг даргын үй ажиллагааны хөтөлбөр

3.2 Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1 Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт

4.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт /Сумын Засаг даргын

Тамгын газар/

4.3 Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн

хэрэгжилт

4.4 Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

5.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

5.3 Хөндлөнгийн үнэлгээ

ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛД ХИЙСЭН ОНЦЛОХ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

6.1 Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний

сумын даргын хүлээх үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан

шинэлэг ажил

ДОЛОО. ДҮГНЭЛТ

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

СУМЫН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР
ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 03 дүгээр сарын 20

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын зорилтын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх сайн туршлагаа хуваалцах, харилцан суралцах, цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, удирдамжаар хангахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам", байгууллагын нээлттэй ил тод байдлыг үнэлэхдээ Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ыг тус тус баримтлав.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүү төрийн сангийн хэлтсээс, Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн үнэлгээг шууд хэрэглэсэн.


Хөндлөнгийн үнэлгээг орон нутгаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож буй байдал, хугацаатай тайлан мэдээний чанар, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэргийг үндэслэн дээд шатны удирдах албан тушаалтнуудаас санал асуулгыг хуудсаар авах ажлыг Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс зохион байгуулж үнэлгээнд оруулан тооцов.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний сумын даргын хүлээх үүргийн биелэлтийн үнэлгээг ажлын хэсэг цахимаар итгэлийг сонсон үнэлгээг өгч дүгнэв.

ГУРАВ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ:

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дүгнүүлсэн үнэлгээ, тус хөтөлбөрийн хэрэгжилтийн бодит үр дүнтэй харьцуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэсэн болно.



Дүгнэлт, анхаарах асуудал: Сумдын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж 90,5 хувьтай хэрэгжсэн нь өнгөрсөн үеийнхээс 4,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ урьдчилсан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээг 6.2.1-т заасан арга зүйгээр үнэлэх бүрэн боломжтой байсныг 6.2.2-т заасан арга зүйгээр буюу зорилт, арга хэмжээний хүрсэн түвшнийг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэглэдэг арга зүйг нийтлэг ашигласан байна. Мөн шалгуур үзүүлэлт бүрийг үнэлсэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж хувийг гаргахдаа арга хэмжээний дунджаар гаргасан зэрэг нийтлэг алдаанууд давтан гаргаж байгаад анхаарах хэрэгтэй.

Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг журмын дагуу үнэлж, нотлох баримт, тайлангийн танилцуулгын хамт гаргаж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, үнэлгээг тоон утгаар дүгнүүлсэн байх

Явцын хяналт-шинжилгээ хийгээд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт

Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг үнэлэхдээ 2022-2024 оны эдийн засгийн үзүүлэлтийн төлөвлөлтөд үндэслэн сумдаас ирүүлсэн тайлан мөн аймгийн статистик мэдээ, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, хөдөө аж ахуйн газар, татварын газар, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар гэх мэт дээд шатны байгууллагуудын салбарын статистик мэдээлэлтэй тулган үзэж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан арга зүйг баримтлан үнэлгээг өгөв.




Дүгнэлт, анхаарах асуудал: Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг шинэчлэн баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу гаргуулж дээд шатны байгууллагын статистик мэдээтэй тулгалт хийж дүгнэхэд сумдын үнэлгээний дундаж 74,2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 12,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь сумдын эдийн засгийн үзүүлэлтийг 2022-2024 он хүртэлх төлөвлөлтийг хийж үзүүлэлтүүд өөрчлөгдсөнтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Хамгийн өндөр үнэлгээтэй буюу 80 хувиас дээш үнэлэгдсэн Сайнцагаан, Дэлгэрцогт сумд байна. Хамгийн муу үнэлгээтэй буюу 70 хувиас доош үнэлэгдсэн Адаацаг, Өндөршил, Сайхан-Овоо сумд эдийн засгийн үзүүлэлтийн биелэлтээ нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулах нь зүйтэй байна.

Цаашид сум бүр тухайн жилд дэвшүүлсэн зорилт, хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төлөвлөхдөө эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол үзүүлэлтийг авч суурь түвшинтэй уялдуулж, зорилтот түвшнийг бодитой төлөвлөх, хэрэгжилтийн бодит үр дүнг ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ: Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлэхдээ хэлтсүүдийн дүгнэсэн үнэлгээг шууд хэрэглэв.




Дүгнэлт, анхаарах асуудал: Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн дундаж 81,8 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,6 хувиар буурсан байна.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд сумдын төрийн байгууллагууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Гэрээнд тусгагдсан арга хэмжээг нэг бүрчлэн эзэнжүүлэх, сумдын төсвийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан үр дүнг тооцож ажиллах нь зүйтэй.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцохдоо сумын Засаг




даргын Тамгын газрын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэв.

Дүгнэлт, анхаарах асуудал: Сумдын Засаг даргын тамгын газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг авч тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 15 сумын дундаж үнэлгээ 91 хувьтай байна. Өнгөрсөн оноос 2,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнг тооцохдоо төлөвлөлт, тайлагналтын чанарыг сайжруулж, өөрийн үнэлгээг бодитой өгөх шаардлагатай байна.

Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх 15 сумын төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 95.2 хувьтай байна.




Дүгнэлт, анхаарах асуудал: Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн сумдын дундаж 95.2 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх оноос 4.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цаашид албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг жил 2-оос доошгүй удаа авч судалгааны мөрөөр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон ажиллах.

Аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлж хэвших шаардлагатай байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт

Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлтийг АЗДТГ-ын хэлтсүүдийн мэргэжилтнүүд тусгай боловсруулсан шалгуурын дагуу үнэлгээ өгч дүнг нэгтгэн дүгнэлээ.




Дүгнэлт, анхаарах асуудал: Байгууллагын дотоод үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тухайн жилийн ажилтай уялдуулан өөрчилж боловсруулдаг тул байгууллагын дотоод үйл ажиллагааг тасралтгүй жигд хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

2023 оны хувьд зөвлөмжийн хэрэгжилт, Багийн Засаг дарга нарын үйл ажиллагаа, Батлах хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт, 2023 оны тэргүүлэх чиглэл батлах тухай А/242 тоот захирамжийн хэрэгжилт, Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл явуулах тухай А/107 тоот захирамжийн хэрэгжилт, Төрийн аудитын дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт, Дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилт гэсэн 7 чиглэлийн хүрээнд 11 үзүүлэлтээр үнэлсэн болно. Сумдын үнэлгээний дундаж 86,7 хувьтай байна. Энэ нь өнгөрсөн оноос 6,3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

ТАВ.БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ:

Мэдээллийн ил тод нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг 46 шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайтад байршуулсан мэдээлэлд үндэслэн Төрийн захиргааны, удирдлагын хэлтсээс өгсөн үнэлгээг шууд хэрэглэв. Сумдын үнэлгээний дундаж 62,5% байгаа нь өнгөрсөн үеийнхээс 7,2 хувьтай өссөн үзүүлэлттэй байна.




Дүгнэлт, анхаарах асуудал: Хамгийн бага үнэлгээтэй буюу 50-с доош хувьтай байгаа Дэлгэрхангай, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Өлзийт, Баянжаргалан сумд байна. Хулд, Цагаандэлгэр, Луус, Өндөршил сумдын үнэлгээ өмнөх оноос өссөн ба бусад сумдын үнэлгээ буурсан үзүүлэлттэй байна.

Цаашид орон нутгийн онцлох ажлын мэдээ болон 46 шалгуур үзүүлэлтийн дагуух холбогдох мэдээллүүдээ цаг тухай бүрд нь бүрэн байршуулах шаардлагатай байна.

Шилэн дансны хөтлөлт, ОНХСангийн үнэлгээ

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүү төрийн сангийн хэлтсээс, Орон нутгийн хөгжлийн сангийн үнэлгээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн үнэлгээг шууд хэрэглэсэн.

Сумдын шилэн дансны хөтлөлтийн дундаж 97,5 хувьтай, Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн дундаж 77,5 хувьтай байна.




Дүгнэлт, анхаарах асуудал: Сумдын шилэн дансны хуулийн хэрэгжилт, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн дундаж 87,6 хувьтай хэрэгжиж байна.

Сумдын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бодит үр дүнг нэмэгдүүлэх, мэдээллийг хугацаанд нь байршуулсан эсэхэд байгууллагын удирдлагууд хяналт тавих шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.


Хөндлөнгийн үнэлгээ

Хөндлөнгийн үнэлгээг орон нутгаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож буй байдал, хугацаатай тайлан мэдээг ирүүлсэн байдал, тайлангийн чанар, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэргийг харгалзан дээд шатны удирдах албан тушаалтнуудаас санал асуулгыг хүүдсаар авч нэгтгэн үнэлгээг гаргасан. Сумдын үнэлгээний дундаж 79,9 хувьтай байна.



ЗУРГАА. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ, ОНЦЛОХ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ:

Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3-т заасан үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажлын үр дүнг тухайн сумын тавьсан илтгэлийн дүнг ажлын хэсгийн хүмүүсийн өгсөн үнэлгээний дунджаар тооцлоо.



Дүгнэлт, анхаарах асуудал: Сумдын үнэлгээний дундаж 82.3 хувьтай байна.

Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3-т заасан үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажлын үр дүнг хийсэн онцлох ажлууд, илтгэл бэлтгэсэн байдал, илтгэх ур чадвар гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээг өгч ажлын хэсгийн гишүүдийн дундаж үнэлгээгээр үнэлгээний дүнг гаргасан.

Хийж, хэрэгжүүлсэн ажлаа бүрэн тайлагнах, мэдээллээ ойлгомжтой байдлаар үр дүн талаас нь танилцуулах, бусдад туршлага болохуйц, олон нийт рүү чиглэсэн шинэ санал санаачилга гарган ажиллах шаардлагатай байна.

ДОЛОО. НЭГДСЭН ДҮГНЭЛТ


Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу удирдамж, аргачлал боловсруулан сумдын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгтгэн дүгнэв.

Сумдын Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг 10 үзүүлэлтээр үнэлж, дүгнэн үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын 2024 оны А/88 дугаар захирамжаар баталгаажуулав.

Сумын Засаг дарга, түүний тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 82.3 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 88.7 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж 76.7 хувь, Аймгийн Засаг даргатай

байгуулсан гэрээний үүргийн биелэлт, онцлох ажлын үнэлгээний дундаж 82.3 хувь, Ерөнхий үнэлгээний дундаж 82,5 хувьтай байна.

Үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээний дундаж 82,5 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0,2 хувиар өссөн байна.



Үнэлгээний дүнгээс харахад Өлзийт, Дэрэн, Луус, Цагаандэлгэр, Хулд сумдын үйл ажиллагааны үр дүн өмнөх оноос өссөн, бусад сумдын үйл ажиллагааны үр дүнг өмнөх оноос буурсан байна.

2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газар тэргүүн байр, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар дэд байр, Луус сумын Засаг даргын Тамгын газар гутгаар байр эзэлсэн бол Баянжаргалан, Цагаандэлгэр сумдын Засаг даргын Тамгын газар дутагдалтай үнэлэгдсэн байна.

Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэд тухайн сум, байгууллагын дотоод чанартай үйл ажиллагаанаас сонгож жил бүр өөр шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг тул үүнд онцгойлон анхаарч үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг ахиулж ажиллах нь зүйтэй байна:

Холбогдох журам, аргачлалын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодитой, биелэгдэхүйц, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц байхаар төлөвлөх, гүйцэтгэлийн тайлан нь иж бүрэн, үр дүнд чиглэсэн байхад анхаарах шаардлагатай байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй болгож иргэдийг үнэн зөв,

бүрэн, ойлгомжтой мэдээллээр хангахад анхаарч хуулийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Цаашид тус тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, тогтоосон хугацаанд хэрэгжилтийг ирүүлж, үйл ажиллагааны үр дүнгээ нэмэгдүүлэхэд санаачилгатай ажиллахыг хүсье.

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үр дүнг хагас бүтэн жилээр тооцож, хэрэгжилтийн хувийг өмнөх оноос нэмэгдүүлэх.
2. Цахим хуудасны орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог өмнөх оноос нэмэгдүүлэх
3. Байгууллагын цахим хуудаст мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн байршуулж, ил тод байдлын үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлэх
4. Салбар бүрийн тоон үзүүлэлтийн судалгааг нарийвчлан гаргаж, бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн суурь судалгаанд ашиглах мэдээллийн сан бүрдүүлэн, цахим хуудсанд байршуулах
5. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр дүгнэлт хийж, тодорхой 2-3 арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг хавсралт хүснэгтийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж хэрэгжилт, үр дүнг тооцон 2024 оны 06 сарын 25, 11 сарын 15-ны дотор ХШҮХ-т ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2023 ОН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	суурь үзүүлэлт		Зорилготой түвшин		Хүрсэн түвшин	
			2022 он	2023 он	2022 он	2023 он	2022 он	2023 он
Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт								
		хувь	156	100	118	100		
1	Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	104	100	100	100		
2	Сумын төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	64	100	102	100		
3	Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	86	100	138	100		
4	Хадгаламжийн хүүгийн орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	57	100	108	100		
5	Бууны албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	63	100	124	100		
6	Улсын тэмдэгтийн хураамж орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	32	100	21	21		
7	Хог хаягдлын үйлчилгээ орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	573	100	29	29		
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	0	100	2	2		
9	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжын орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	203	100	179	100		
10	Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	77	100	41	41		
11	Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	73	100	208	100		
12	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	128	100	116	100		
13	Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	0	100	100	100		
14	Газрын дуудлага худалдаанаас орох орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл	хувь	32	45	34	75.5		
15	Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэд	тоо	4	6	9	100		
16	Төсөл, хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болсон ажлын байр	тоо	30	15	23	100		
17	Бий болсон байнгын ажлын байр	тоо	0	2	1	50		
18	Нийгмийн даатгалд шинээр хамрагдсан ААН байгууллага	тоо	377	386	140	36.2		
19	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэд	тоо	80	85	96.2	100		
20	Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт	хувь	100	100	100	100		
21	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	хувь	58.6	63.6	65	100		
22	Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	1	0	0	100		
23	Хоршоо хөгжүүлэх сангийн муу зээлдэгчийн бууралт	тоо	1	0	4	100		
24	Тухайн жилд шинээр гаргасан худгийн тоо	тоо	0	3	5	100		
25	Тухайн жилд сэргээн засварласан худаг	тоо	87	100	100	100		
26	Тухайн жилд бэлтгэсэн аюулгүйн нөөцийн өвс	хувь	27	100	68	68		
27	Тухайн жилд бэлтгэсэн аюулгүйн нөөцийн тэжээл бүрдүүлэлт	хувь	0	1	0	0		
28	Тэжээлийн ургамал, тариалсан талбай хэмжээ	га	1	1	0	0		
29	Хураан авсан малын тэжээл бусад	тн	1	1	0	0		

Нийгмийн хөгжлийн үзүүлэлт						
		19	70	79	100	
30	Тоон гарын үсгийн олголт	хувь	3	3	7	10
31	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	41.5	60	100	100
32	Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт	хувь	44.1	60	44.5	74.1
33	Зөрчилд оногдуулсан торгууль, хүү торгуулийн орлогын биелэлт	хувь	0	2	18.3	100
34	Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ	га	0	0		
35	Төвлөрсөн хогийн цэгийг шууж булшилсан талбайн хэмжээ	тоо	4521	5100	3420	67
36	Шинээр тарьсан мод	хувь	75	76	90	90
37	Ургалтын хувь	хувь	0.30	0.36	0.36	100
38	Хот суурины эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь	хувь	0	0	0	100
39	100.000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	промилль	0	0	0	100
40	1.000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	0	0	0	100
41	10.000 хүн амд вируст гепатитын өвчлөл	промилль	0	0	0	100
42	Тухайн жилийн товлोलт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	97	98	98.1	100
43	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамрагдалт	хувь	94.8	95	100	100
44	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамрагдалт	хувь	89.7	90	100	100
45	Жирэмсний эрт хяналтын хувь	хувь	86.5	100	100	100
46	Жирийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамрагдалт	хувь	80	95	50	0
47	Сувилагчийн хангалтын хувь	промилль	7	4.5	4.4	100
48	Сүрьеэгийн өвчлөл (10 000 хүн амд)	промилль	0	0	0	100
49	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	промилль	0	0	0	100
50	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	хувь	28.3	30	33.3	100
51	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь	хувь	54	59	91.3	100
52	Бага боловсролын хамран сургалтын хувь	хувь	91	94	97.4	100
53	6 настны хамран сургалтын хувь	хувь	100	100	100	100
54	8 настны хамран сургалтын хувь	хувь	85.1	87.1	86.6	75
55	Суурь боловсролын хамран сургалтын хувь	тоо	72.4	73.5	83.6	100
56	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж оноо	хувь	100	100	80	0
57	Мэргэжлийн багшийн хангалт (сургуулийн өмнөх боловсрол)	хувь	100	100	96.7	0
58	Мэргэжлийн багшийн хангалт (ерөнхий боловсролын сургууль)	хувь	100	100	100	100
59	Дотуур байрны хангалт	хувь	100	100	100	100
60	Цэцэрлэгийн бүлгийн 1 багшид ноогдох хүүхдийн тоо	тоо	29	30	31	100
61	Бага ангийн багшид ноогдох хүүхдийн тоо	тоо	19	20	19	10
62	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	тоо	504	505	505.3	100
63	Зохион байгуулсан соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээ	тоо	82	110	120	100
64	Соёл, урлагийн арга хэмжээнд хамрагдсан иргэд	тоо	10948	11005	9325	84.7
65	Өрхийн угийн бичиг хөтлөлт	хувь	45.4	47	45.5	10
66	Хамтарсан багийн гишүүдийн Nams программ ашиглалт	хувь	0	100		
					77.64	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа	Хамтран хэрэгжүүлэгч
		3	4	5	6	7	8
1	2						
1							
2							
3							

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН
ДАРГА
 ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН
МЭРГЭЖИЛТЭН.....

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	
		3	4	5	6	7	8	
1	2							
1								
2								
3								
	Хэрэгжилтийн дундаж хувь							

ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАСАН
ДАРГА
 ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН
МЭРГЭЖИЛТЭН.....